



НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН  
АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ

2009 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

СЭЛБЭГ МАТЕРИАЛ АВАХ ТУХАЙ

Албаны техникийн комиссын 2009 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Тус байгууллагын албан ажлын хэрэгцээний 20-37 УБН номерийн "Жинбэй" маркийн автомашинд 4 ширхэг амортизатор худалдан авахад 100000 /нэг зуун мянган/ төгрөг гаргахыг нягтлан бодогч /З. Сэргэлэн/-д зөвшөөрсүгэй .

Хоёр. Албаны ажлын хэрэгцээний авто машины ашиглалт, техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйлчилгээг тогтмол хийлгэж, хяналт тавьж ажиллахыг техникийн комисс дарга /Ч.Батсайхан/-д даалгасугай.



ДАРГА

Б.ИНЖИННАШ



НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ

ДАРГА *Б. Инжиннаш* Б.ИНЖИННАШ

**ТЕХНИКИЙН КОМИССЫН АКТ**

2009 оны .....сарын ..... өдөр

Улаанбаатар хот.

Нийслэлийн Агаарын чанарын албаны дэд дарга Ч.Батсайхан, нягтлан бодогч З.Сэргэлэн, мэргэжилтэн О.Алтангэрэл, Ц.Мөнхбат, Г.Даваажаргал нарын гурэлдэхүүнтэй техникийн комисс нь жолооч Ж.Батбаатарыг оролцуулан УБН 2 0-37 Улсын номертой "Жинбэй" маркийн автомашины техникийн байдлыг шалгаж үзлээ.

1. Уг авто машины хувийн хэргээс үзэхэд УБН 20- 37 номертой авто машин нь 2007 онд ашиглалтанд орсноос хойш их болон урсгал засвар хийгдээгүй .
2. Улсын 20-37 УБН номертой "Жинбэй" маркийн уг авто машиныг шалгаж үзэхэд: 4 ширхэг амортизатороос тос гарч ажиллах чадваргүй болсон нь тогтоогдлоо.

**Комиссоос тогтоох нь:**

1. Уг эвдэрлүүдийг дахин засварлах боломжгүй тул шинээр авч тавих шаардлагатай гэж үзэв.
2. Энэ машин нь байнга шахам гэр хорооллын шороон замаар явдаг учраас эвдрэл ихтэйгээс гадна одоо уг машины хувьд сэлбэг авах хугацаа нь нэгэнт болчихсон байна. Хэрвээ одооноос анхаарахгүй бол цаашид эдэлгээнд орж бусад зөөлөн эд ангиа муутгах аюултай байна.
3. Эдэлгээний явцад гарсан техникийн эвдрэл тул зардлыг байгууллагаас гаргах нь зүйтэй гэж үзэв.

Комиссын дарга: *Ч.Батсайхан* Ч.Батсайхан

Гишүүд: *О.Алтангэрэл* О.Алтангэрэл

*Ц.Мөнхбат* Ц.Мөнхбат

*Г.Даваажаргал* Г.Даваажаргал

Зөвшөөрсөн жолооч: *Ж.Батбаатар* Ж.Батбаатар